УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2022/73/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2022 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Т.Амармэнд<br>Утас: 70453721, Цахим хаяг: amarmendt@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....3
3. Аудитын тайлан.....12
3.1 Ерөнхий зүйл.....12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....12
3.4 Материаллаг байдал.....13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....15
3.8 Аудитын гол асуудал.....15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....16
4. Аудитын илрүүлэлт.....16
4.1Залруулсан алдаа.....16
5.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....17

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № УВА-2022/173/НА-СТА-ТШЗ
танай________-ны №__________-т

ӨНДӨРХАНГАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ГЭРЭЛЦЭЦЭГ ТАНАА

## Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

0200200348

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **59,654,948.00** | **30,070,948.45** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 00.00 |
| **33** | **АВЛАГА** | 4,000,000.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 4,000,000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 4,000,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 55,654,948.00 | 30,070,948.45 |
| **354** | **Хангамжийн материал** | 55,654,948.00 | 30,070,948.45 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 7,448,108.00 | 7,448,108.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,240,490.00 | 15,656,490.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,190,000.00 | 1,190,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 31,776,350.00 | 5,776,350.45 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,068,493,098.52** | **1,317,836,497.87** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,068,493,098.52 | 1,317,836,497.87 |
| **392** | **Биет хөрөнгө** | 986,273,098.52 | 1,234,866,497.87 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 939,883,973.08 | 1,047,828,273.08 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -333,575,863.48 | -378,311,549.40 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 98,223,600.00 | 216,128,600.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -75,891,878.07 | -38,090,878.19 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 480,843,460.20 | 535,593,260.20 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -256,725,818.84 | -291,214,657.36 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 32,775,073.97 | 36,623,539.97 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -21,837,940.33 | -20,537,169.78 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 206,758,689.00 | 225,038,689.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -84,180,197.01 | -98,191,609.65 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 82,220,000.00 | 82,970,000.00 |
| 39301 | Програм хангамж | 2,305,000.00 | 3,055,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,305,000.00 | -2,305,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 82,220,000.00 | 82,220,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,128,148,046.52** | **1,347,907,446.32** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,128,148,046.52** | **1,347,907,446.32** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,128,148,046.52 | 1,347,907,446.32 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 746,186,599.17 | 746,186,599.17 |
| 51101 | Өмч: - төрийн | 746,186,599.17 | 746,186,599.17 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 80,863,654.77 | 300,468,674.37 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 80,863,654.77 | 80,909,274.57 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 219,759,399.80 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 301,097,792.58 | 301,052,172.78 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,128,148,046.52** | **1,347,907,446.32** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **566,683,713.00** | **831,102,912.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **00.00** | **00.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **79,617,530.00** | **324,537,600.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 79,617,530.00 | 324,537,600.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 79,617,530.00 | 324,537,600.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 5,939,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 79,617,530.00 | 318,598,100.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **487,066,183.00** | **506,565,312.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 66,439,983.00 | 65,548,812.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 7,446,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 65,918,483.00 | 57,250,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 521,500.00 | 852,812.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 420,626,200.00 | 441,016,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 420,626,200.00 | 441,016,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **728,335,384.32** | **611,343,512.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **679,061,984.32** | **590,843,512.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 617,616,578.75 | 563,853,092.75 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 254,016,664.00 | 262,573,214.08 |
| 210101 | Үндсэн цалин | 210,293,954.00 | 218,602,839.77 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 43,722,710.00 | 43,970,374.31 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,647,302.91 | 34,119,984.37 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,962,101.49 | 24,176,225.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,550,441.56 | 2,606,819.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,041,291.83 | 2,039,697.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 488,535.59 | 476,260.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,604,932.44 | 4,820,981.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 28,669,467.52 | 38,413,314.20 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,026,512.00 | 1,830,784.32 |
| 210302 | Түлш, халаалт | 26,642,955.52 | 36,582,529.88 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,654,125.00 | 23,269,779.90 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,867,960.00 | 2,361,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,699,260.00 | 16,804,480.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,126,805.00 | 2,730,199.90 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 160,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 960,100.00 | 1,214,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 00.00 | 500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,617,600.00 | 2,793,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 330,000.00 | 206,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,287,600.00 | 2,587,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,497,000.00 | 4,135,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,497,000.00 | 4,135,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,372,378.00 | 31,643,189.55 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,136,360.00 | 30,102,811.55 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 288,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 136,200.00 | 89,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 111,974.00 | 58,974.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 414,500.00 | 330,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 391,344.00 | 752,304.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 261,142,041.32 | 166,904,610.65 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,244,520.00 | 62,309,110.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,450,000.00 | 380,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 235,447,521.32 | 104,214,700.65 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 61,445,405.57 | 26,990,419.45 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 42,136,200.00 | 12,483,384.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 40,716,700.00 | 00.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 11,653,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,419,500.00 | 829,984.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 19,309,205.57 | 14,507,035.45 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,309,205.57 | 14,507,035.45 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **49,273,400.00** | **20,500,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 49,273,400.00 | 20,500,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 49,273,400.00 | 20,500,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-161,651,671.32** | **219,759,399.80** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-161,651,671.32** | **219,759,399.80** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **501,038,183.00** | **516,504,812.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **00.00** | **00.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **5,939,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 5,939,500.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 5,939,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 5,939,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **501,038,183.00** | **510,565,312.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 80,411,983.00 | 69,548,812.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 7,446,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 79,890,483.00 | 57,250,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 521,500.00 | 4,852,812.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 420,626,200.00 | 441,016,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 420,626,200.00 | 441,016,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **451,094,783.00** | **467,004,812.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **451,094,783.00** | **467,004,812.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **385,639,377.43** | **440,014,392.55** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 254,016,664.00 | 262,573,214.08 |
| 210101 | Үндсэн цалин | 210,293,954.00 | 218,602,839.77 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 43,722,710.00 | 43,970,374.31 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,647,302.91 | 34,119,984.37 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,962,101.79 | 24,176,225.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,550,441.56 | 2,606,819.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,041,291.83 | 2,039,697.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 488,535.59 | 476,260.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,604,932.14 | 4,820,981.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,650,927.52 | 38,413,314.20 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,026,512.00 | 1,830,784.32 |
| 210302 | Түлш, халаалт | 25,624,415.52 | 36,582,529.88 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,285,905.00 | 23,269,779.90 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,408,060.00 | 2,361,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,431,040.00 | 16,804,480.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,886,805.00 | 2,730,199.90 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 200,000.00 | 160,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,360,000.00 | 1,214,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 500,000.00 | 416,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 500,000.00 | 416,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,615,600.00 | 11,753,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 531,000.00 | 586,000.00 |
| 210602 | Тавилга | 1,000,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,084,600.00 | 11,167,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,497,000.00 | 4,135,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,497,000.00 | 4,135,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,862,878.00 | 2,643,190.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,366,360.00 | 1,102,812.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 288,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 136,200.00 | 89,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 111,974.00 | 58,974.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 675,000.00 | 330,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 391,344.00 | 752,304.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 26,563,100.00 | 62,689,910.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,963,100.00 | 62,309,110.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,600,000.00 | 380,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **65,455,405.57** | **26,990,419.45** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 42,146,200.00 | 12,483,384.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 40,716,700.00 | 00.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 11,653,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,429,500.00 | 829,984.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 23,309,205.57 | 14,507,035.45 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **49,943,400.00** | **49,500,000.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **00.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **49,943,400.00** | **49,500,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **49,943,400.00** | **49,500,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 49,943,400.00 | 49,500,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 49,273,400.00 | 49,500,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 670,000.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-49,943,400.00** | **-49,500,000.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **710,330,599.17** | **301,097,792.58** | **242,515,326.09** | **1,253,943,717.84** |
| **C02** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **C03** | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 710,330,599.17 | 301,097,792.58 | 242,515,326.09 | 1,253,943,717.84 |
| **C04** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **C05** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **C06** | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **C07** | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -161,651,671.32 | -161,651,671.32 |
| **C08** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **746,186,599.17** | **301,097,792.58** | **80,863,654.77** | **1,128,148,046.52** |
| **D01** | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **746,186,599.17** | **301,097,792.58** | **80,863,654.77** | **1,128,148,046.52** |
| **D02** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 45,619.80 | 45,619.80 |
| **D03** | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 746,186,599.17 | 301,097,792.58 | 80,909,274.57 | 1,128,193,666.32 |
| **D04** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -45,619.80 | 00.00 | -45,619.80 |
| **D05** | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **D06** | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **D07** | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **D08** | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 219,759,399.80 | 219,759,399.80 |
| **D09** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **746,186,599.17** | **301,052,172.78** | **300,668,674.37** | **1,347,907,446.32** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| ЭЗА | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 437,016,500.00 | 432,448,964.55 | 4,567,535.4 | 99.0 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 437,016,500.00 | 432,448,964.55 | 4,567,535.4 | 99.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 424,530,100.00 | 419,965,580.55 | 4,564,519.4 | 98.9 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 263,013,000.00 | 262,573,214.08 | 439,785.9 | 99.8 |
| 210101 | Үндсэн цалин | 218,644,700.00 | 218,602,839.77 | 41,860.2 | 100.0 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 44,368,300.00 | 43,970,374.31 | 397,925.7 | 99.1 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,506,900.00 | 34,119,984.37 | 1,386,915.6 | 96.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,986,200.00 | 24,176,225.07 | 809,974.9 | 96.8 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,630,200.00 | 2,606,819.45 | 23,380.5 | 99.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,104,200.00 | 2,039,697.76 | 64,502.2 | 96.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 526,000.00 | 476,260.17 | 49,739.8 | 90.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,260,300.00 | 4,820,981.92 | 439,318.1 | 91.6 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 39,128,800.00 | 38,413,314.20 | 715,485.8 | 98.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,107,200.00 | 1,830,784.32 | 276,415.7 | 86.9 |
| 210302 | Түлш, халаалт | 37,021,600.00 | 36,582,529.88 | 439,070.1 | 98.8 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,463,700.00 | 18,162,779.90 | 300,920.1 | 98.4 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,587,000.00 | 2,331,100.00 | 255,900.0 | 90.1 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,000,600.00 | 11,997,480.00 | 3,120.0 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,748,000.00 | 2,730,199.90 | 17,800.1 | 99.4 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 166,600.00 | 160,000.00 | 6,600.0 | 96.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 961,500.00 | 944,000.00 | 17,500.0 | 98.2 |
| **2105** | **Нормативт зардал** | 416,500.00 | 416,500.00 | 0.0 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 416,500.00 | 416,500.00 | 0.0 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,768,000.00 | 11,753,500.00 | 14,500.0 | 99.9 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 600,000.00 | 586,000.00 | 14,000.0 | 97.7 |
| 210604 | Урсгал засвар | 11,168,000.00 | 11,167,500.00 | 500.0 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,233,100.00 | 4,135,000.00 | 1,098,100.0 | 79.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,233,100.00 | 4,135,000.00 | 1,098,100.0 | 79.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,328,600.00 | 1,790,378.00 | 538,222.0 | 76.9 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 250,000.00 | 250,000.00 | 0.0 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 403,200.00 | 288,000.00 | 115,200.0 | 71.4 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 136,200.00 | 89,100.00 | 47,100.0 | 65.4 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 125,800.00 | 58,974.00 | 66,826.0 | 46.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 88,000.00 | 22,000.00 | 66,000.0 | 25.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 565,400.00 | 330,000.00 | 235,400.0 | 58.4 |
| 210807 | Газрын төлбөр | 760,000.00 | 752,304.00 | 7,696.0 | 99.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 48671500.00 | 48600910.00 | 70,590.0 | 99.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,255,000.00 | 48,220,110.00 | 34,890.0 | 99.9 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 416,500.00 | 380,800.00 | 35,700.0 | 91.4 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 12486400.00 | 12483384.00 | 3,016.0 | 100.0 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 00.00 | 00.00 | 0.0 | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,486,400.00 | 12,483,384.00 | 3,016.0 | 100.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,653,400.00 | 11,653,400.00 | 0.0 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 833,000.00 | 829,984.00 | 3,016.0 | 99.6 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **00.00** | 0.0 | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 437,016,500.00 | 442,956,000.00 | -5,939,500.0 | 101.4 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 437,016,500.00 | 437,016,500.00 | 0.0 | 100.9 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 437,016,500.00 | 437,016,500.00 | 0.0 | 100.9 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 00.00 | 5,939,500.00 | -5,939,500.0 | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 5,939,500.00 | -5,939,500.0 | |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 28.00 | 28.00 | 0.0 | 100 |
| 620001 | Удирдах ажилтан | 08.00 | 08.00 | 0.0 | 100 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 09.00 | 09.00 | 0.0 | 100 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 11.00 | 11.00 | 0.0 | 100 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **28.00** | **28.00** | 0.0 | 100 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 09.00 | 09.00 | 0.0 | 100 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 06.00 | 06.00 | 0.0 | 100 |
| 650010 | Гэрээт ажилтан | 06.00 | 06.00 | 0.0 | 100 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 07.00 | 07.00 | 0.0 | 100 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **20,048,812.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **20,048,812.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 20,048,812.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | | 5,107,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 30,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 4,807,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 270,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 852,812.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 852,812.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 14089000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 14,089,000.00 |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **49,500,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 49,500,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | | 49,500,000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 69548812.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 69,548,812.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 7,446,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 4,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 57,250,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 852,812.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | 00.00 |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар нь Засгийн газар болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ, мэдээллээр хангах, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй хүргэх үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 5,826.6 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 611,343.5 мянган төгрөгийн 1 хувиар буюу 6,113.4 мянган төгрөгийн 80 хувиар тооцож 4,890.7 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цагалбарт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 249,559.4 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 4,000.0 | 0.0 | -4,000.0 |
| Бараа материал | 55,654.9 | 30,070.9 | -25,584.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,068,493.1 | 1,317,636.4 | 249,143.3 |
| **Нийт хөрөнгө** | 1,128,148.0 | 1,347,707.4 | 219,559.4 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,128,148.0 | 1,347,707.4 | 219,559.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,347,707.4 | 1,347,707.4 | 219,559.4 |

Авлага дансны өмнөх оны үлдэгдлийг бүрэн барагдуулсан байна. Тайлант онд авлага үүсээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 30,070.9 мянган төгрөг болж 25,584.0 мянган төгрөгөөр буурчээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,317,636.4 мянган төгрөг болж 249,143.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд шинээр нэмэгдсэн хөрөнгө байна. Тайлант онд 51,944.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 34,960.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 278,318.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,347,707.4 мянган төгрөг болж 219,559.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь шинээр хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 458,105.6 мянган төгрөгөөр буюу 122 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь дээд шатны төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 93.385.2 мянган төгрөгөөр буюу 18 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан цалин, НДШ, гэрэл цахилгаан, түлш халаалт, бичиг хэрэг, тээвэр шатахуун, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга 45.6 мянган төгрөгөөр хийгдсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 316,681.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 316,681.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 59,831.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 376,513.1 мянган төгрөгөөр баталсныг тодотгол хийж 60,503.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 437,016.5 мянган төгрөгөөр баталжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 437,016.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 437,016.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 441,016.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 5,939.5 мянган төгрөг оруулж, нийт 446,956.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 432,448.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үндсэн данснаас 14,507.0 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 432,448.9 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 61,250.0 мянга, хандив тусламжийн орлого 7,446.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 852.8 мянга, нийт 69,548.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 5,107.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 852.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 14,089.0 мянга, хөрөнгийн зардалд 49,500.0 мянга нийт 69,548.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал байхгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149, хугацаа хоцроож мэдээлсэн 1 мэдээлэл байна. Мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 127.0 мянган төгрөгийн зөвлөмж өгснийг 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 74 дүгээр албан бичгээр биелэлтийг ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А/43 дугаар захирамжаар сумдын Засаг даргын тамгын газрын, багийн бүтэц орон тоог батлахдаа гэрээт ажилтны орон тоог батлаагүй байна. Дараагийн аудитаар энэ асуудлыг анхаарч шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 95,569.2 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрснээс 95,569.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин дотоод томилолт, бараа үйлчилгээний бусад зардал, шуудан холбоо, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг шууд зардалд бүртгэсэн 91,569.2 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залрууллаа.

### 4.4 Зөвлөмж

1. ***Хууль тогтоомжийн хэрэгжилттэй асуудал***

*1.1.* *<u>Илрүүлэлт:</u>* Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дах заалтад “Санхүү, төсвийг зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 6.4.8 дахь заалтад “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3 дахь заалтад “Бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчин 2020 онд Өндөрхангай сумын Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдсэн баруун голын гүүрний засварын үлдэгдэл 4,000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлт дансанд төвлөрүүлснийг санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн боловч гүйцэтгэгч компанид өгөх өглөг бүртгээгүй байна. Тайлант онд санхүүгийн тайланд тусгаагүй дээрх өглөгийг гүйцэтгэгч компанид шилжүүлсэн байна.

1.2. *<u>Өгсөн зөвлөмж</u>*: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3 дахь заалтад “Бүх өр төлбөр” заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 04 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Өндөрхангай сумын ЗДТГ | 2 | 95,569.2 | 1 | 91,569.2 | | | | | 1 | 4,000.0 |
| **ДҮН** | | 2 | 95,569.2 | 1 | 91,569.2 | | | | | 1 | 4,000.0 |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР /Т.АМАРМЭНД/

2022 оны 02 сарын 25-ны өдөр